



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/34

Чойбалсан


Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "л", Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2020 оны 194 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/269 дүгээр тушаал, аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар хуралдааны шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2020 оны "Бэлэн байдлын зэргийг бууруулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" А/567 дугаар захирамжийн 1 дүгээр заалтын үйлчлэлд хамаарах "сургалтын төв, фитнес бялдаржуулах төв, спорт заалны үйл ажиллагаа" гэж заасан хэсгийн хязгаарлалтыг 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс хэсэгчлэн цуцалж өөрчлөлт оруулсугай.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар хуралдааны тэмдэглэлд заасан эрүүл ахуйн шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, эрсдлийг бууруулах зорилгоор хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Д.Мөнхтуяа/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Т.Ганзориг/, Эрүүл мэндийн газар /Ч.Оюунаа/ сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбатад даалгасугай.



ЗАСАГ ДАРГА

М.БАДАМСҮРЭН